


**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим хаяг:
orgil.ikhul@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
Орлогын данс	12
Зардлын данс	12
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



БҮРЭНТОГТОХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.АЗЗАЯА ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/285
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 6 иргэнтэй холбоотой 29.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Бүрэнтогтох сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 90.2 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	962,011.9	510,772.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	339,242.2	288,243.0
33	АВЛАГА	132,251.3	90,202.0
35	БАРАА МАТЕРИАЛ	490,518.5	132,327.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,274,260.9	1,364,620.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	54,398.1	172,000.0
37300	Урт хугацаат зээл	54,398.1	172,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,219,862.8	1,192,620.5
39200	Биет хөрөнгө	6,994,838.8	1,139,647.2
39300	Биет бус хөрөнгө	225,024.1	52,973.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,236,272.8	1,875,393.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	166,839.2	48,767.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	166,839.2	48,767.4
41300	Өглөг	166,839.2	48,767.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,069,433.6	1,826,625.8
51	Засгийн газрын хувь оролцоо	8,069,433.6	1,826,625.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,174,991.3	658,095.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,174,991.3	658,095.2
51200	Хуримтлагдсан үр дүн	4,257,970.6	634,938.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,636,471.8	533,592.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,236,272.8	1,875,393.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,754,856.8	1,918,610.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	252,604.4	455,454.0
110	Орлогын албан татвар	73,459.2	217,151.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,459.2	232,148.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-14,996.6
113	Хөрөнгийн албан татвар	98,333.1	153,337.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	80,812.1	84,965.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,078,393.7	150,526.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,078,393.7	150,526.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,423,858.7	1,312,629.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,853,146.9	1,661,235.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,853,146.9	1,661,235.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,692,347.7	1,572,126.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,963,958.4	439,329.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,322.1	53,640.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	502,236.6	642,978.0
2104	Хангамж, бараа материалын зардал	121,105.4	51,808.3
2105	Нормативт зардал	336,099.9	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,667.3	148,580.4
2107	Томилолт, зочны зардал	3,716.8	1,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,276.0	88,888.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	441,965.1	145,002.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,799.2	89,108.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	901,709.9	257,374.6

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	166,138.9	6,532,235.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	735,571.0	-6,274,860.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,708,603.2	1,830,680.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	252,604.4	455,454.0
110	Орлогын албан татвар	73,459.2	217,151.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,459.2	232,148.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-14,996.6
113	Хөрөнгийн албан татвар	98,333.1	153,337.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	80,812.1	84,965.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,368.8	16,280.5
1181	Газрын төлбөр	10,145.5	17,064.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	54,297.9	48,136.5
1183	Бусад татвар	0.0	3,483.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	106,823.3	62,596.6
120	Нийтлэг татварын бус орлого	106,823.3	62,596.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,349,175.6	1,312,629.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,282,287.8	1,605,876.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,282,287.8	1,605,876.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,136,893.1	1,336,337.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,964,979.0	438,698.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,861.6	53,040.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	515,323.8	643,612.9
2104	Хангамж, бараа материалын зардал	111,138.3	46,692.4
2105	Нормативт зардал	153,049.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,297.5	50,178.1
2107	Томилолт, зочны зардал	3,716.8	1,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,118.4	81,076.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,408.4	21,137.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,394.7	269,539.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	426,315.4	224,803.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	251,150.2	103,802.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	251,150.2	103,802.6
2200	Дотоод эх үүсвэрээр	251,150.2	103,802.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-251,150.2	-103,802.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-172,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	172,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	175,165.3	-50,999.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	164,076.9	339,242.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	339,242.2	288,243.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/Мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,985,010.5	0.0	6,985,010.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	380,966.6	0.0	380,966.6

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,365,977.1	0.0	7,365,977.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-31,044.9	0.0	-31,044.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-1,069.6	0.0	-1,069.6
6	Тайлант үеийн үр дүн	735,571.0	0.0	735,571.0
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,069,433.6	0.0	8,069,433.6
8	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,069,433.6	0.0	8,069,433.6
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	32,052.7	0.0	32,052.7
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,101,486.3	0.0	8,101,486.3
11	Тайлант үеийн үр дүн	-6,274,860.6	0.0	-6,274,860.6
12	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,826,625.8	0.0	1,826,625.8

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,038,128.7	1,812,668.3	225,460.4	88.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,738,128.7	1,541,985.7	196,143.0	88.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,330,886.9	1,281,844.3	49,042.6	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,619.3	438,698.6	28,920.7	93.8
210101	Үндсэн цалин	357,966.8	327,773.8	30,193.0	91.6
210102	Нэмэгдэл	85,211.2	88,637.6	-3,426.4	104.0
210104	Урамшуулал	13,941.3	15,069.9	-1,128.6	108.1
210105	Гэрээт ажлын хөлс	10,500.0	7,217.2	3,282.8	68.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,321.9	53,040.6	4,281.3	92.5
210201	Тэтгэврийн даатгал	39,551.6	36,640.5	2,911.1	92.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,442.7	4,100.0	342.7	92.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,554.2	3,280.3	273.9	92.3
210204	Ажилгүйдлийн даатгал	888.4	819.9	68.5	92.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,885.0	8,200.0	685.0	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	646,030.2	643,612.9	2,417.3	99.6
210301	Гэрэл, цахилгаан	31,022.4	34,110.1	-3,087.7	110.0
210302	Түлш, халаалт	610,807.8	607,252.8	3,555.0	99.4
210303	Цэвэр, бохир ус	4,200.0	2,250.0	1,950.0	53.6
2104	Хангамж, бараа материалын зардал	44,451.4	43,951.4	500.0	98.9
210401	Бичиг хэрэг	8,370.0	8,370.0	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	23,470.2	22,970.2	500.0	97.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900.0	3,900.0	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	1,500.0	1,500.0	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,418.4	1,418.4	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,792.8	5,792.8	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,381.9	55,298.0	83.9	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,200.0	5,200.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	50,181.9	50,098.0	83.9	99.8
2107	Томилолт, зочны зардал	1,900.0	1,900.0	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	1,900.0	1,900.0	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,872.5	28,933.2	11,939.4	70.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,942.5	26,049.5	11,893.0	68.7
210803	Даатгалын үйлчилгээ	180.0	133.7	46.4	74.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.0	200.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50.0	50.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,900.0	1,900.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	600.0	600.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,309.7	16,409.7	900.0	94.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,083.4	16,083.4	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,226.3	326.3	900.0	26.6

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	407,241.8	260,141.3	147,100.5	63.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	369,315.3	222,214.9	147,100.4	60.2
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	369,315.3	222,214.9	147,100.4	60.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,926.5	37,926.4	0.1	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,926.5	33,926.4	0.1	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.0	4,000.0	0.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000.0	98,682.7	1,317.3	98.7
223001	Бусад хөрөнгө	100,000.0	98,682.7	1,317.3	98.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	172,000.0	28,000.0	86.0
230001	Эргэж төлөгдөх зээл	200,000.0	172,000.0	28,000.0	86.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,038,128.7	1,698,626.1	339,502.6	83.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	139,861.0	139,861.0	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	139,861.0	139,861.0	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,522,228.5	1,510,188.5	12,040.0	99.2
320001	Орон нутгийн төсвөөс	1,522,228.5	1,510,188.5	12,040.0	99.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	376,039.2	48,576.6	327,462.6	12.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	201,500.0	44,347.5	157,152.5	22.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000.0	4,229.1	-2,229.1	211.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	172,539.2	0.0	172,539.2	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	159,765.9	-159,765.9	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	45,723.6	-45,723.6	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,484.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,484.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,459.6
2104	Хангамж, бараа материалын зардал	2,316.0
210401	Бичиг хэрэг	300.0
210402	Тээвэр, шатахуун	1,976.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,143.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,143.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,025.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,875.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,875.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	150.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	150.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,484.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,484.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,637.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,847.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Бүрэнтогтох сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл

авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Хүүхэд хамгаалал залуучуудын хөгжлийг дэмжих жил” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 90.2 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, байгууллага, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/143 тоот тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 13 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, байгууллагын албан хэрэг хөтлөлт, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-

ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,360.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөгөөр/		
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	339.2	288.2	-51.0
Авлага	132.3	90.2	-42.0
Бараа материал	490.5	132.3	-358.2
Үндсэн хөрөнгө	7,219.9	1,192.6	-6,027.2
Нийт хөрөнгө	8,236.3	1,875.4	-6,360.9
Өр төлбөр	166.8	48.8	-118.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,069.4	1826.6	-6,242.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,236.3	1,875.4	-6,360.9

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 51.0 сая төгрөгөөр буурсан бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 242.5 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 32.2 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэлд 13.5 сая төгрөг нийт 288.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлагын үлдэгдэлд ОНХС-ийн дансанд бүртгэлтэй Нарлаг хөхий ХХК-аас авах 19.5 сая төгрөгийн зураг төсвийн үнийн авлага, ЗДТГ-ын НДШ-ийн 0.9 сая төгрөгийн авлага, засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага 0.15 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага 69.8 сая төгрөгийн авлага нийт 96.2 сая төгрөгийн авлагатай байна.
Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 42.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 6 иргэнтэй холбоотой 29.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 444.1 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 170.1 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 64.4 сая төгрөг, Соёлын төв 11.2 сая төгрөг, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор 58.7 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 139.5 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургуулийн 2,571.9 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 280.6 сая төгрөг, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор 733.2 сая төгрөг, Соёлын төв 910.6 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 1,590.1 сая төгрөг нийт 6,086.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.
5. Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь Соёлын төвийн 114.3 сая төгрөгийн өглөг, Бүрэнхаан багийн Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор 3.0 сая төгрөгийн өглөг өглөгийн

данснаас хасаж тайлагнасан болон ЗДТГ-ын 0.6 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг барагдуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,918.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,836.2 сая төгрөгөөр буюу 59.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Татварын орлого	252.6	455.4	202.8	80.2
Татварын бус орлого	1,078.3	150.5	-927.8	86.0
Тусламж санхүүжилтийн орлого	3,423.8	1,312.6	-2,111.8	61.7
Нийт дүн	4,754.8	1,918.6	-2,836.2	59.6

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,751.8 сая төгрөгийн орлогын давхардсан 16 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,598.5 сая төгрөгийн орлогын давхардсан 14 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 1,661.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 2,191.9 сая төгрөгөөр буюу 56.9 хувиар буурсан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,853.1	1,661.2	-2,191.9	56.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	166.1	6,532.2	6,366.1	3832.6
НИЙТ	4,019.3	8,193.5	4,174.2	203.9

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Үйл ажиллагааны нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 56.9 хувь болж буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд үйл ажиллагааны бус зардал нэмэгдсэн нь "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,751.8 сая төгрөгийн орлогын давхардсан 16 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,598.5 сая төгрөгийн орлогын давхардсан 14 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Бүрэнтогтох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 50 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,938.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,492.2 сая төгрөгийг урсгал зардалд, 344.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээл олгох 102.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 149.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 1,258.6 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 395.2 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1.5 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 133.9 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн жилийн явцад 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоол, Аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 01-ний өдрийн А/429 дүгээр захирамжаар төсвийн тодотгол, зохицуулалт хийж төсвийн орлого зарлагыг 2,038.1 сая төгрөг болгон баталсан байна.

Нийт зардлын 395.1 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 139.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,101.3 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 198.4 сая төгрөгийг давсан орлого дансны үлдэгдлээс, 202.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1.5 сая төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 1,101.2 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 408.7 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 139.8 сая, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 47.0 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1.9 сая төгрөгийг нийт 1,698.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Бүрэнтогтох сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолд зааснаар Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 395.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 469.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 118.7 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	145.0	156.2	11.2	107.7
Үйл ажиллагааны орлого	13.0	14.3	1.3	110.7
Хөрөнгийн орлого	25.0	25.1	0.1	100.8
Хөрөнгө борлуулсны орлого	2.9	6.2	3.1	206.5
Шууд бус орлого	17.9	30.1	12.2	168.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15.0	-14.9	0.3	100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2.7	4.1	1.4	154.8
Бууны албан татвар	3.2	4.0	0.8	125.6
Малд ногдуулах албан татвар	120.0	145.1	25.1	120.9
Улсын тэмдэгтийн хураамж	7.4	6.6	-0.7	89.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	9.7	9.6	-0.1	98.7
Газрын төлбөр	6.8	17.0	10.2	250.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.1	4.2	4.0	2265.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0	0.005	0.005	
Ойн нөөц ашигласны төлбөр	45.1	43.8	-1.3	97.2
Торгуулийн орлого	9.6	13.2	3.6	138.2
Түрээсийн орлого	1.5	0.325	-1.1	21.6
НИЙТ ОРЛОГО	395.1	469.1	73.8	118.7

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Бүрэнтогтох сумын орон нутгийн орлого 73.8 сая төгрөгөөр давж биелэхэд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 11.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 1.4 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 3.2 сая төгрөг, шууд бус орлого 12.2 сая төгрөг, ААНБ болон иргэдийн худалдан авах чадвар сайжирсантай холбоотойгоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 1.4 сая төгрөгөөр, өмнөх оны малын албан татварын ногдлыг тайлант онд төлүүлсэнтэй холбоотойгоор малд ногдуулах албан татвар 25.1 сая төгрөгөөр, газрын нөхөн бүрдүүлэлтийн хийгдсэнтэй холбоотой өмнөх оны өр төлбөрийг хураан барагдуулж газрын төлбөр 10.2 сая төгрөгөөр, хяналт шалгалтын үр дүнгээс хамааран торгуулийн орлого 3.6 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 1.3 сая төгрөг, түрээсийн орлого 1.1 сая төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө биелээгүй ба нийт 4 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 3.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 45.2 сая төгрөгөөр төлөвлөж 29.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 12.9 сая төгрөг буюу 28.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ /40/	3.5	0.0145	3.5
2	АТБӨЯХ	13.2	22.7	9.5
3	Зам ашигласны төлбөр	5.0	6.3	1.3
4	Түрээсийн орлого	0.9	0	0.9
5	Нэр заагдаагүй бусад орлого	22.6	29.1	6.5
	Нийт дүн	45.2	58.1	12.9

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл түрээсийн орлого 0.9 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 3.5 сая төгрөгөөр нийт 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 4.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2.4 сая төгрөгөөр төлөвлөж 4.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 1.7 сая төгрөгөөр буюу 70.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	0.9	0.6	-0.3
2	НӨАТатвар	0.8	0.2	-0.6
3	Агаарын бохирдол /авто/	0.7	3.3	2.6
	Нийт дүн	2.4	4.1	1.7

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 0.3 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 0.6 сая төгрөгөөр тус тус тасарсан ба нийт 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 0.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1,865.6 сая төгрөгөөр төлөвлөж, 1,698.6 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2,038.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,738.1 сая төгрөгийг урсгал зардалд, 100.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 200.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1541.9 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 98.6 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлд 172.0 сая төгрөгийг олгон зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,812.7 сая төгрөг буюу 88.9 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 28.9 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 2.4 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 0.5 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 11.9 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 0.9 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 147.1 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 1.3 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээл 28.0 сая төгрөг олгоогүй байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 18 төсөл арга хэмжээнд 263.3 сая төгрөг батлагдсанаас 16 төсөл арга хэмжээнд 222.2 сая төгрөгийг зарцуулж 45.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Санхүүжилт 29.7 сая төгрөг орон нутгаас олгох санхүүжилт дутуу олгосон байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 1,812.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 88.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа Засаг даргын тамгын газар нь дээд шатны төсөв захирагчаас 6.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 49.8 сая төгрөг бүрдүүлжээ. Үүнд:

- Нүүрс худалдан борлуулсны орлого 32.7 сая төгрөг
- цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг
- Өвсний орлого 8.3 сая төгрөг
- Тендерийн орлого 0.6 сая төгрөг байна.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 54.5 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 2.0 сая төгрөг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 0.15 сая төгрөг төвлөрүүлэн авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 77.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 61.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас 2 Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжсэнээр тайлант оны үйл ажиллагааны зардлын дүн буурсан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 1,661.2 сая төгрөгийг сонгож 26.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор харьяа байгууллагуудын төсөвт нийт 44.1 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 203.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-

Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	6	203.4	4	154.7	66
Нийт дүн	6	203.4	4	154.7	66

Өмнөх оны 203.4 сая төгрөгийн 6 зөвлөмжөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Өр төлбөртэй холбоотой зөвлөмжийн биелэлт нь өр төлбөрийн үлдэгдэл буурсан байна. Орлого бүрдүүлэлттэй холбоотой, мөн хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлттэй холбоотой зөвлөмжийн биелэлт бүрэн биелээгүй байгаа ба тайлант онд орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ даван биелсэн нэр төрлөөрөө тасарсан, хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлт өмнөх оноос зээлдэгчийн тоо их болсон зэргийг харгалзан үзэж зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 7 төсвийн байгууллага, 3 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсролын, соёл, эрүүл мэндийн салбарын 5 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 139.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 101.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 38.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

Залруулсан алдааны талаар:

- Харьяа байгууллагуудын төвлөрүүлсэн 44.1 сая төгрөгийн төсвийн тохируулга, хоорондын тооцоо хийлгэж, ТТЗ-ийн нэгдсэн тайланд орхиж нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн дансны 56.5 сая төгрөг, өөрийн орлого 0.4 сая төгрөгийг нэмж бүртгэж, тайланд нэгтгүүлэн нийт 101.0 сая төгрөгийн залруулга хийсэн.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчлийн талаар:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 11.3 сая төгрөгийн алдаа залруулж, 40.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, Шилэн дансны цахим системд мэдээллийг байршуулаагүй, төсөв хэтрүүлэн зарцуулсан 486.3 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

1.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 6 иргэнтэй холбоотой 29.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. Орлого бүрдүүлэлтийн талаар

2.1 Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 1.3 сая төгрөг, түрээсийн орлого 1.2 сая төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө биелээгүй ба нийт 3.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 0.3 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 0.6 сая нийт 0.9 төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл түрээсийн орлого 0.9 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 3.5 сая төгрөгөөр нийт 4.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

2.2 Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	3	101.0	3	101.0			3	101.0				
Харьяа байгууллагуудын алдаа												
Бүрэнтогтох сумын ЗДТГ	1	11.3	1	11.3			1	11.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улс, аймаг, орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө биелээгүй.	1	8.6					1	8.6				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулаагүй	1	29.7					1	29.7				

